

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
3.1	Балансын данстай холбоотой асуудал.....	10
3.2	Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4	аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
5	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ
ЭМНЭЛГИЙН ДАРГА Г.БАЯСГАЛАН
ТАНАА

2019.02.25 № 06/221
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дугаар зүйлд заасны дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн дарга Г.Баясгалан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 25-наас 2019 оны 02 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал, аудитын багийн ахлагч Т.Одончимэг, ахлах аудитор Б.Цогзолмаа, О.Цэндхүү чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг, аудиторын туслах Т.Алтанчимэг, М.Сэржмядаг, Д.Эрдэнэбаяр нар хариуцаж хэрэгжүүлэв.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 6/56 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгов.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь "Эрүүл мэндийн цогц, шуурхай, чанартай үйлчилгээг өндөр мэдлэг бүхий эмч, мэргэжилтнүүд, дэвшилтэт технологид тулгуурлан үзүүлж үйлчлүүлэгчийн амьдралын чанарыг сайжруулна" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дурангийн мэс засал
- Лабораторийн үйлчилгээ
- Уян дурангийн оношлогоо, эмчилгээ
- Бөөр судлал
- Эрчимт эмчилгээ, яаралтай тусламж
- Өвдөлт намдаах тусламж, үйлчилгээ
- Диабетийн тусламж, үйлчилгээ
- Сэргээн засах

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
- Дархлаажуулалтын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Нийгмийн даатгалын тухай хуульд ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 1 хувиар нэмэгдүүлсэн. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хэмжээнээс шалтгаалан шатлалтай болсон.ы

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Улсын хоёрдугаар төв эмнэлэг санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Даймонд” програм хангамж ашигладаг байна.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Улсын хоёрдугаар төв эмнэлгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод

хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 43 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийн 1.0 хувиар тооцов.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгосон нь тус эмнэлэг нь төрийн үйлчилгээ үзүүлэх зорилготой байгууллага тул нийт зардал нь үйл ажиллагааны цар хүрээг илтгэх хамгийн тохиромжтой үзүүлэлт гэж үнэлсэнтэй холбоотой юм.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 1.0 хувиар тооцсон нь тус эмнэлгийн үйл ажиллагааны цар хүрээ, төсвийн санхүүжилтийн хэмжээ өндөр байгаа тул эрсдлийг агуулж байх магадлалтай гэж үзсэнтэй холбоотой юм.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 12,487,469.1 мянган төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 124,874.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр 48 горим сорил гүйцэтгэж үнэлэхэд, 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 42 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд 3 асуудалд залруулга хийлгэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/мянган төгрөгөөр/				
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	910.4	
	Дүн	2	910.4	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулсан. Бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал үүсээгүй.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитад дараах асуудлыг бүрэн шалгаж амжаагүй тул дараагийн тайлангийн жилд доорх асуудалд анхаарал хандуулна. Үүнд:

- Өндөр өртөгтэй мэс заслын зардлын санхүүжилт, түүнийг нэхэмжилсэн байдал бараа материалын зарцуулалттай тохирч байгаа эсэх;
- Худалдан авалт хийж буй эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ тариф нь зах зээлийн үнээс өндөр байгаа эсэхийг судлах;

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой зургаан хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 11,252,978.4 мянган төгрөгийн төсөв батлагдсан. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 2018 онд тус эмнэлэг нь 11,252,978.4 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөн 11,119,276.2 мянган төгрөгийн зардал гаргаж 126,460.4 мянган төгрөгийн зардал хэмнэсэн байна. Хэмнэлт нь өндөр өртөгтэй мэс заслын зардал 130,606.8 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулахад нийт 3 ангилал бүхий 20 төрлийн 160 мэдээлэл оруулахаас 160 мэдээллийг иж бүрэн байршуулсан.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББООУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Улсын хоёрдугаар төв эмнэлгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тус эмнэлгийн эмийн захиалга, олголт, зарцуулалтад 6 тасгийн 110 өвчний түүхийг хамруулан шалгахад дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Хүүхдэд эмчийн бичсэнээр 50 гр шингэн хийх байтал эмнэлгийн тендерээр худалдан авдаг шингэн 100 граммаас дээш хэмжээтэй ирдгээс шалтгаалж 61660 гр натри хлорид, 54100 гр рингер буюу 910.4 мянган төгрөгийн шингэн асгасан, 50 граммаар захиалах саналыг тендерийн баримт бичигт тусгадаггүй;
- Өвчний түүхэнд эмчилгээний заалтыг дутуу бичсэнээс эм, тариа зарцуулагдах үндэслэлтэй эсэх нь нотлогдохгүй;
- Эм тарианы буцаалтын дэвтрээс 4 өдрийн бүртгэлийн дэвтрийг тасгийн буцаалттай тулган шалгахад 15 нэр төрлийн 286 ширхэг зөрүүтэй;

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалт, анхан шатны баримттай тохирохгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Худалдан авч буй рингер, натри гэх мэт шингэнийг 50 граммаар худалдан авч шингэн асгалтын хэмжээг багасгах, төсвийг хэмнэлттэй зарцуулах, эм тарианы зарцуулалт, буцаалтыг өвчний түүх болон эм тарианы буцаалтын дэвтэрт үнэн зөв хөтлөх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулахад хүлээн зөвшөөрсөн.

3.2 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

3.2.1 Илрүүлэлт:

2016 онд Бона Вита ХХК-тай ШЧ-037/2016 тоот хамтран ажиллах гэрээг 1 жилийн хугацаатай байгуулсан. Гэрээнд тус эмнэлэг нь Бона Вита ХХК-д шинжилгээ авах орчин нөхцөлөөр хангах үүрэг хүлээж, түрээсийн төлбөр, ашиглалтын зардлыг сар бүр хүлээн авахаар тусгаж, түрээсийн төлбөрт 2017 онд 11,650.0 мянган төгрөгөөр тус эмнэлгийн шалыг хулдааслуулсан байна. Харин уг гэрээний хугацаа 2017 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөр дуусвар болж, гэрээг сунгаагүй 2018 онд үйл ажиллагаа явуулж, тайлант онд түрээсийн төлбөр төлөөгүй байна.

Энэ нь “Эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслэх журам"-ын 13-д “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг байгуулахдаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан түрээсийн гэрээний үлгэрчилсэн загварыг үндэс болгоно”, гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Төрийн өмчийн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээр бусдад түрээслүүлэх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн хөрөнгийг бусдад түрээслүүлэхдээ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслэх журам"-ыг мөрдөж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тус асуудлыг асуудлын бүртгэлээр танилцуулахад тайлбар өгнө гэж тайлбарласан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	942,753,023.43	976,065,744.75
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	13,041.75	9,000.00
33	АВЛАГА	-	45,000,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага		45,000,000.00
34	УРЬДЧИЛГАА	10,206,774.51	11,682,300.00
34600	Урьдчилж гарсан зардал	10,206,774.51	4,382,300.00
3471	Урьдчилгаа тооцоо	-	7,300,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	932,533,207.17	919,374,444.75
351	Түүхий эд материал	192,536,613.93	139,548,591.51
35110	Тусгай зориулалттай материал	25,067,334.00	14,395,042.88
35130	Эм боох материал	167,469,279.93	125,153,548.63
354	Хангамжийн материал	739,996,593.24	779,825,853.24
35410	Бичиг хэргийн материал	5,297,608.50	5,477,072.99
35420	Аж ахуйн материал	6,945,341.00	15,714,908.58
35430	Сэлбэг хэрэгсэл	591,220.00	77,780.00
35440	Түлш, шатах тослох материал	3,450,274.00	4,036,773.93
35450	Барилгын засварын материал	3,329,607.50	2,994,162.50
35460	Хүнсний материал	14,049,130.52	5,582,345.12
35470	Бусад хангамжийн материал	706,333,411.72	745,942,810.12
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,536,404,412.27	10,014,371,518.18
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,536,404,412.27	10,014,371,518.18
392	Биет хөрөнгө	4,523,869,734.39	8,491,556,999.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,471,256,160.98	7,093,560,640.35
39202	Хуримтлагдсан элэгдэл	-6,742,257,573.64	-10,040,075.30
39203	Авто-тээврийн хэрэгсэл	238,151,618.00	238,151,618.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-203,927,913.31	-211,788,772.04
39205	Машин тоног төхөөрөмж	6,036,748,443.89	6,089,030,614.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	-4,700,580,442.39	-5,145,884,668.99
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,373,163,276.96	1,344,904,982.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	-948,745,166.81	-1,050,715,591.14
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,848,767.50	206,951,859.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,787,436.79	-62,613,608.16
393	Биет бус хөрөнгө	12,534,677.88	1,522,814,518.81
39301	Програм хангамж	81,862,350.00	93,062,350.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-69,327,672.12	-75,173,091.19
39303	Бусад биет бус хөрөнгө		1,504,925,260.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,479,157,435.70	10,990,437,262.93
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,178,370.68	21,478,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,178,370.68	21,478,000.00
414	Урьдчилж орсон орлого	-	21,478,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,475,979,065.02	10,968,959,262.93
51	Засгийн газрын хувь оролцоо	5,475,979,065.02	10,968,959,262.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	10,436,361,816.42	11,941,287,076.42
51101	Өмч: - төрийн	10,436,361,816.42	11,941,287,076.42
512	Хуримтлагдсан үр дүн	(5,311,308,154.54)	(5,944,118,046.05)
51210	Өмнөх үеийн үр дүн	(5,532,415,892.28)	(5,311,308,154.54)
51220	Тайлант үеийн үр дүн	221,107,737.74	(632,809,891.51)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	350,925,403.14	4,971,790,232.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,479,157,435.70	10,990,437,262.93

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	12,015,030,783.24	11,854,659,226.73
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,747,278,729.24	1,966,305,126.73
120	Нийтлэг татварын бус орлого	2,747,278,729.24	1,966,305,126.73
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,747,278,729.24	1,966,305,126.73
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,077,960,923.42	1,357,305,342.58
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	74,170,936.00	95,847,315.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,595,146,869.82	513,152,469.15
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,267,752,054.00	9,888,354,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,797,323,900.00	2,797,207,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,797,323,900.00	2,797,207,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	83,488,600.00	230,956,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,175,000.00	143,595,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	51,313,600.00	87,361,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,386,939,554.00	6,860,189,900.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	6,386,939,554.00	6,860,189,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	11,793,923,045.50	12,487,469,118.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,793,923,045.50	12,487,469,118.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,572,976,787.50	12,316,306,425.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,367,120,896.00	4,423,822,577.00
210101	Үндсэн цалин	2,884,440,745.00	2,976,808,492.00
210102	Нэмэгдэл	838,748,857.00	793,803,401.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	323,008,563.00	328,298,400.00
210104	Урамшуулал	320,922,731.00	324,912,284.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	480,762,605.49	535,701,908.51
210201	Тэтгэврийн даатгал	395,829,594.49	452,034,673.51
210205	Эрүүл мэндийн даатгал	84,933,011.00	83,667,235.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	420,890,709.59	440,245,444.49
210301	Гэрэл, цахилгаан	152,782,884.00	170,190,126.00
210302	Түлш, халаалт	158,647,882.00	171,592,660.00
210303	Цэвэр, бохир ус	109,459,943.59	98,462,658.49
2104	Хангамж, бараа материалын зардал	254,959,230.19	322,854,084.85
210401	Бичиг хэрэг	37,832,257.00	32,655,900.51
210402	Тээвэр, шатахуун	46,293,073.00	38,830,180.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,313,220.00	12,069,735.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	77,429,687.73	86,352,518.92
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	80,090,992.46	152,945,749.92
2105	Нормативт зардал	4,440,197,119.71	5,192,738,112.52
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,155,865,692.76	4,940,823,020.59
210502	Хоол, хүнс	190,062,940.10	191,058,250.99
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	94,268,486.85	60,856,840.94

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	484,107,774.75	83,652,154.12
210604	Урсгал засвар	484,107,774.75	83,652,154.12
2107	Томилолт, зочны зардал	4,868,500.00	6,744,960.00
210701	Гадаад албан томилолт	741,000.00	4,032,960.00
210702	Дотоод албан томилолт	4,127,500.00	2,712,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,720,920.00	11,921,844.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,934,100.00	6,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	647,460.00	588,060.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	842,060.00	539,660.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	264,000.00	220,000.00
210807	Газрын төлбөр	4,049,100.00	4,115,924.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	984,200.00	458,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,108,349,031.77	1,298,625,340.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,027,314.00	97,403,275.96
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,054,321,717.77	1,201,222,064.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	220,946,258.00	171,162,692.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	218,727,970.00	163,920,878.51
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	169,202,600.00	139,193,312.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	49,525,370.00	24,727,566.51
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,218,288.00	7,241,813.77
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,218,288.00	7,241,813.77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	221,107,737.74	(632,809,891.51)
5	НИЙТ ҮР ДҮН	221,107,737.74	(632,809,891.51)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>10,415,177,901.75</u>	<u>11,357,470,638.00</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,147,425,847.75	1,469,116,538.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,147,425,847.75	1,469,116,538.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,147,425,847.75	1,469,116,538.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,023,925,099.00	1,307,405,509.00
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	123,500,748.75	161,711,029.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,267,752,054.00	9,888,354,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,797,323,900.00	2,797,207,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,797,323,900.00	2,797,207,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	83,488,600.00	230,956,700.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	32,175,000.00	32,175,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	111,420,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	51,313,000.00	87,361,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,386,939,554.00	6,860,189,900.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	6,386,939,554.00	6,860,189,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	<u>10,367,641,460.00</u>	<u>11,284,039,779.75</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>10,367,641,460.00</u>	<u>11,284,039,779.75</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>10,059,357,572.00</u>	<u>11,092,604,653.98</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,198,977,500.00	4,352,493,110.00
210101	Үндсэн цалин	3,541,756,400.00	2,519,648,000.00
210102	Нэмэгдэл	247,104,000.00	1,150,334,310.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	120,287,000.00	288,688,500.00
210104	Урамшуулал	264,209,400.00	357,403,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	25,620,700.00	36,419,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	461,045,200.00	522,734,200.00
210201	Тэтгэврийн даатгал	293,392,400.00	348,489,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	41,913,200.00	43,561,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	33,530,600.00	34,848,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,382,600.00	8,712,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	83,826,400.00	87,122,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	424,451,998.59	439,043,500.00
210301	Гэрэл, цахилгаан	152,782,884.00	169,025,231.51
210302	Түлш, халаалт	162,209,171.00	171,592,660.00
210303	Цэвэр, бохир ус	109,459,943.59	98,425,608.49
2104	Хангамж, бараа материалын зардал	174,092,455.00	195,676,200.00
210401	Бичиг хэрэг	14,515,430.00	15,787,230.00
210402	Тээвэр, шатахуун	39,900,000.00	39,463,682.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,417,170.00	11,875,035.00
210404	Ном, хэвлэл		14,491,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	80,799,274.00	102,138,752.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,460,581.00	11,920,501.00

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	2,613,715,093.91	2,929,251,699.98
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,293,191,408.11	2,589,996,899.98
210502	Хоол, хүнс	228,309,835.80	241,159,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	92,213,850.00	98,094,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	116,697,872.50	100,309,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	31,762,400.00	22,219,143.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,049,100.00	
210604	Урсгал засвар	73,886,372.50	78,090,757.00
2107	Томилолт, зочны зардал	5,838,000.00	5,512,000.00
210701	Гадаад албан томилолт	2,800,000.00	2,800,000.00
210702	Дотоод албан томилолт	3,038,000.00	2,712,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,989,220.00	93,685,820.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,280,000.00	66,280,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,934,100.00	6,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	709,460.00	588,060.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	842,060.00	539,660.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	202,000.00	220,000.00
210807	Газрын төлбөр	4,049,100.00	4,090,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,612,500.00	3,073,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,360,000.00	12,894,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,006,550,232.00	2,453,898,224.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,996,845,232.00	2,419,256,824.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,705,000.00	34,641,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	308,283,888.00	191,435,125.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	306,065,600.00	139,193,312.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	169,202,600.00	139,193,312.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	136,863,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,218,288.00	52,241,813.77
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,218,288.00	52,241,813.77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>47,536,441.75</u>	<u>73,430,858.25</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	49,170,300.00	73,434,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	49,170,300.00	73,434,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	49,170,300.00	73,434,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	49,170,300.00	73,434,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>(49,170,300.00)</u>	<u>(73,434,900.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(1,633,858.25)	(4,041.75)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,646,900.00	13,041.75
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,041.75	9,000.00

4.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,436,361,816.42	353,441,830.86	5,532,415,892.28	5,257,387,755.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		-2,516,427.72		-2,516,427.72
Тайлант үеийн үр дүн			221,107,737.74	221,107,737.74
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,436,361,816.42	350,925,403.14	5,311,308,154.54	5,475,979,065.02
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,436,361,816.42	348,408,975.42	5,090,200,416.80	5,475,979,065.02
НБББ-ын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,436,361,816.42	350,925,403.14	5,311,308,154.54	5,475,979,065.02
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	1,504,925,260.00	4,620,864,829.42		6,125,790,089.42
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн			-632,809,891.51	-632,809,891.51
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,941,287,076.42	4,971,790,232.56	5,944,118,046.05	10,968,959,262.93

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		13,041.75	(13,041.75)	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,252,978,400.00	11,119,276,165.98	133,702,234.02	99%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,252,978,400.00	11,119,276,165.98	133,702,234.02	99%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,111,124,500.00	10,980,082,853.98	131,041,646.02	99%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,346,118,700.00	4,346,118,110.00	590.00	100%
210101	Үндсэн цалин	2,513,273,000.00	2,513,273,000.00	-	100%
210102	Нэмэгдэл	1,150,334,900.00	1,150,334,310.00	590.00	100%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	288,688,500.00	288,688,500.00	-	100%
210104	Урамшуулал	357,403,200.00	357,403,200.00	-	100%
210105	Гэрээт ажлын хөлс	36,419,100.00	36,419,100.00	-	100%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	522,734,200.00	522,734,200.00	-	100%
210201	Тэтгэврийн даатгал	348,489,500.00	348,489,500.00	-	100%
210202	Тэтгэмжийн даатгал	43,561,200.00	43,561,200.00	-	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	34,848,900.00	34,848,900.00	-	100%
210204	Ажилгүйдлийн даатгал	8,712,200.00	8,712,200.00	-	100%
210205	Эрүүл мэндийн даатгал	87,122,400.00	87,122,400.00	-	100%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	439,043,500.00	439,043,500.00	-	100%
210301	Гэрэл, цахилгаан	168,713,800.00	168,713,800.00	-	100%
210302	Түлш, халаалт	171,638,500.00	171,638,500.00	-	100%
210303	Цэвэр, бохир ус	98,691,200.00	98,691,200.00	-	100%
2104	Хангамж, бараа материалын зардал	169,003,300.00	169,003,300.00	-	100%
210401	Бичиг хэрэг	6,708,800.00	9,607,330.00	(2,898,530.00)	143%
210402	Тээвэр, шатахуун	38,699,700.00	39,463,682.00	(763,982.00)	102%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,492,400.00	11,875,035.00	5,617,365.00	68%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	102,739,900.00	102,138,752.00	601,148.00	99%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,362,500.00	5,918,501.00	(2,556,001.00)	176%
2105	Нормативт зардал	2,841,890,700.00	2,841,890,699.98	0.02	100%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,502,635,900.00	2,502,635,899.98	0.02	100%
210502	Хоол, хүнс	241,159,900.00	241,159,900.00	-	100%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	98,094,900.00	98,094,900.00	-	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	145,638,400.00	145,638,400.00	-	100%
210601	Багаж, техник, хэрэгсэл	69,235,900.00	67,776,143.00	1,459,757.00	98%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,394,000.00	1,394,000.00	-	100%
210604	Урсгал засвар	75,008,500.00	76,468,257.00	(1,459,757.00)	102%
2107	Томилолт, зочны зардал	2,882,400.00	2,712,000.00	170,400.00	94%
210702	Дотоод албан томилолт	2,882,400.00	2,712,000.00	170,400.00	94%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	93,949,700.00	93,685,820.00	263,880.00	100%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	66,280,000.00	66,280,000.00	-	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл	6,000,000.00	6,000,000.00	-	100%

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	тогтоох				
210803	Даатгалын үйлчилгээ	642,000.00	588,060.00	53,940.00	92%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	705,600.00	539,660.00	165,940.00	76%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	264,000.00	220,000.00	44,000.00	83%
210807	Газрын төлбөр	4,090,000.00	4,090,000.00	-	100%
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,073,600.00	3,073,600.00	-	100%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	12,894,500.00	12,894,500.00	-	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,549,863,600.00	2,419,256,824.00	130,606,776.00	95%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,549,863,600.00	2,419,256,824.00	130,606,776.00	95%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	141,853,900.00	139,193,312.00	2,660,588.00	98%
2132	Бусад урсгал шилжүүлэг	141,853,900.00	139,193,312.00	2,660,588.00	98%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	141,853,900.00	139,193,312.00	2,660,588.00	98%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,252,978,400.00	11,119,272,124.23	133,706,275.77	99%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,797,207,500.00	2,789,965,686.23	7,241,813.77	100%
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,797,207,500.00	2,789,965,686.23	7,241,813.77	100%
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,860,189,900.00	6,860,189,900.00	-	100%
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	6,860,189,900.00	6,860,189,900.00	-	100%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,595,581,000.00	1,469,116,538.00	126,464,462.00	92%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,470,789,000.00	1,314,157,024.00	156,631,976.00	89%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	124,792,000.00	154,959,514.00	(30,167,514.00)	124%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		13041.75	(13,041.75)	0%
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		9000.00	(9,000.00)	0%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100%
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	413	413	0	100%
620001	Удирдах ажилтан	4	3	1	75%
620002	Гүйцэтгэх ажилтан	273	268	5	98%
620003	Үйлчлэх ажилтан	136	136	0	100%
620004	Гэрээт ажилтан		6	-6	0%
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО		100,145	(100,145)	0%
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо		9,110	(9,110)	0%
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо		91,035	(91,035)	0%

5 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

Огноо: 2019/02/15	Аудитын нэр:	Улсын хоёрдугаар төв эмнэлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит	Аудитын код: САГ-2019/392/ СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Улсын 2 дугаар төв эмнэлэг	Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
				Албан тушаал	Овог нэр
A	3	4	8	9	10
1	Тус эмнэлгийн эмийн захиалга, олголт, зарцуулалтад 6 тасгийн 110 өвчний түүхийг хамруулан шалгахад дараах зөрчил илэрсэн. Үүнд: - Хүүхдэд эмчийн бичснээр 50 гр шингэн хийх байтал эмнэлгийн тендерээр авдаг шингэн 100 граммаас дээш хэмжээтэй ирдгээс шалтгаалж 61660 гр натри хлорид, 54100 гр рингер буюу 910.4 мянган төгрөгийн шингэн асгасан, 50 граммаар захиалах саналыг тендерийн баримт бичигт тусгадаггүй - Өвчний түүхэнд эмчилгээний заалтыг дутуу бичсэнээс эм, тариа зарцуулагдах үндэслэлтэй эсэх нь нотлогдохгүй - Эм тарианы буцаалтын дэвтрээс 4 өдрийн бүртгэлийн дэвтрийг тасгийн буцаалттай тулган шалгахад 15 нэр төрлийн 286 ширхэг зөрүүтэй	910.4	Зөвлөмж өгсөн	Дарга Ахлах нягтлан бодогч	Г.Баясгалан А.Байгалсүрэн
2	2016 онд Бона Вита ХХК-тай ШЧ-037/2016 тоот хамтран ажиллах гэрээг 1 жилийн хугацаатай байгуулсан. Гэрээнд тус эмнэлэг нь Бона Вита ХХК-д шинжилгээ авах орчин нөхцөлөөр хангах үүрэг хүлээж, түрээсийн төлбөр, ашиглалтын зардлыг сар бүр хүлээн авахаар тусгаж, түрээсийн төлбөрт 2017 онд 11,650.0 мянган төгрөгөөр тус эмнэлгийн шалыг хулдааслуулсан байна. Харин уг гэрээний хугацаа 2017 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөр дуусвар болж, гэрээг сунгаагүйгээр 2018 онд үйл ажиллагаа явуулсан байна	-	Зөвлөмж өгсөн	Дарга Ахлах нягтлан бодогч	Г.Баясгалан А.Байгалсүрэн
	ДҮН	910.4			

